



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД АХМАДЫН САН АЖИЛЛУУЛАХ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН
ҮҮРГЭЭ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14.7 ДАХЬ ХЭСГИЙН
ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН
АУДИТЫН КОД: НАГ-2025/20-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Б.Баттуяа

Утас: 260949, Цахим хаяг: battuyab@audit.gov.mn

Арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга

Утас: 329875, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Аудитын менежер П.Ундармаа

Утас: 261839, Цахим хаяг: undarmaap@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор Н.Хандмаа

Цахим хаяг: khandmaan@audit.gov.mn

Аудитор Н.Түмэнцэцэг

Цахим хаяг: tumentsetsegn@audit.gov.mn

Аудитор М.Минжин

Цахим хаяг: minjinm@audit.gov.mn

Аудитор М.Отгонбаяр

Цахим хаяг: otgonbayarm@audit.gov.mn

Өгөгдлийн шинжилгээний аудитор Б.Эрдэнэхүү

Цахим хаяг: erdenehuub@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Дархан-Уул аймаг дахь аймаг дахь Төрийн аудитын газар (Ш.Мөнхбаяр), Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар (Б.Болортуул)-т тус тус даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд (Т.Аубакир)-д зөвлөсүгэй.

5. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Б.Мөнхдөл)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaaf\2025\EA-In A Tushaaf\1114 NAG-1.Docx

1525010007

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 11 дүгээр сарын 14 өдрийн
А/133 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага,
тогтоосон төлбөрийн актын жагсаалт

№	Хэрэгжүүлэх байгууллага	Аудитын шийдвэр				
		Шийдвэрийн нэр	Хүргүүлсэн хугацаа	Дугаар	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Хэрэгжүүлэх хугацаа
1	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар	Төлбөрийн акт	2025.10.10	78	4,500.0	2026.06.20
2	Дорнод аймгийн Онцгой байдлын газар	Төлбөрийн акт	2025.10.10	77	5,100.0	2026.06.20
3	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	Төлбөрийн акт	2025.10.10	76	330.0	2025.11.20
4	Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар	Албан шаардлага	2025.09.30	1/119	8,700.0	2025.11.01
5	Дорнод аймаг дахь Политехник коллеж	Албан шаардлага	2025.10.10	247	14,000.0	2026.11.25
6	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар	Албан шаардлага	2025.10.10	249	22,000.0	2026.11.25
7		Албан шаардлага	2025.10.10	250	5,200.0	2026.11.25
8	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Албан шаардлага	2025.10.10	254		2026.11.25
9	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	Албан шаардлага	2025.10.10	248	4,814.3	2026.11.25
10	Дорнод аймгийн Онцгой байдлын газар	Албан шаардлага	2025.10.10	251	5,100.0	2026.11.25
11		Албан шаардлага	2025.10.10	252	3,300.0	2026.11.25
12		Албан шаардлага	2025.10.10	253	3,600.0	2026.11.25

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл.....	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
БҮЛЭГ 1. АХМАДЫН САН БАЙГУУЛАХ, ДАНС НЭЭХ, ТҮҮНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	8
Ахмад настны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр төсвийн байгууллагууд “Ахмадын сан” байгуулан ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.....	8
Төсөвт байгууллагууд “Ахмадын сан” байгуулан ажиллуулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	9
БҮЛЭГ 2. АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИХ, НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	11
Төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.	11
Ахмадын сангийн хөрөнгийг хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	12
ДҮГНЭЛТ	14
ЗӨВЛӨМЖ	15
Хавсралт.....	16
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	17
Үндэсний аудитын газрын тайлбар	21

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 ¹ дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" 2025 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтад тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүн" сэдэвт нийцлийн аудитыг гүйцэтгэв.
АУДИТЫН КОД	НАГ-2025/20-ШТА-НА
АУДИТЫН ЗОРИЛГО	Ахмад настны тухай хуулийн 14.7 ² дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүнд нийцлийн аудит хийж, тайланг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтийн эрх ашигт нийцсэн дүгнэлт зөвлөмж гаргахад чиглэгдэв. Ахмадын сангийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж буй дараах асуудлаар дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Үүнд: - Төрийн байгууллагууд тухайн жилийн цалингийн сангийн тодорхой хувийг төлөвлөж, ахмадын сан байгуулан холбогдох дансанд төвлөрүүлсэн эсэх; - Ахмадын сангийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ	Аудитад Ахмад настны тухай хуулийн хүрээнд сан байгуулан данс нээж, эх үүсвэрийг төсөвт тусган ажиллах заалтыг хэрэгжүүлэх төсөвт байгууллагуудыг /2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар/ түүвэрчлэн хамруулж, мэдээ, судалгаа болон бусад баримт материалд үндэслэн гүйцэтгэв.
АУДИТЫН АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Аудитад АДБОУС 100, нийцлийн аудитын стандарт АДБОУС 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын

¹ Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аудитын сэдэв батлах тухай" 05 дугаар тогтоол

² Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлд 14.7 дахь хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

байгууллагын аудит хийх журам”, “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг мөрдөж ажиллав.

Аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглав.

Ахмад настны тухай хууль, “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын заалтуудыг шалгуур үзүүлэлт болгов. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг³;
- Ахмадын сан байгуулан ажиллуулах журам⁴.

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитыг Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга арга зүйгээр хангаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Ундармаа хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Наранбаатар, аудитор Н.Хандмаа, Н.Түмэнцэцэг, М.Минжин, М.Отгонбаяр, өгөгдлийн шинжилгээний аудитор Б.Эрдэнэхүү нар аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Санхүүгийн аудитын газар болон Аймаг, Нийслэл дэх төрийн аудитын газрууд аудитын гүйцэтгэлийн үе шатанд оролцсон болно.

АУДИТЫН ХЯЗГААРЛАЛТ

Аудитыг төрийн аудитын стандарт, тавигдах бусад шаардлага, арга зүйн дагуу гүйцэтгэж аудитын асуудал бүрээр дүн шинжилгээ хийж энэхүү тайланд тусгав.

Төрийн аудитын байгууллагын 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлд тодорхойлсон эрсдэл, аудитын төлөвлөгөө, горим сорилд үндэслэсэн илрүүлэлт дүгнэлтүүд нь зөвхөн хууль эрх зүйн хязгаарлалтын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгаанд хийсэн дүн шинжилгээний үр дүн болно.

³ Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг “Энэ хуулийн 14.6³-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.”

⁴ Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас Ахмад настны тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд хуулийн зорилго нь ахмад настны эрхийг хамгаалах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн үүргийг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдэнэ гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.6.16⁵-т “Хүн амын бүлгүүд, тухайлбал ...ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.”, 3.1.13⁶-т “Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.”, 3.1.18⁷-т “Ахмад настан ... үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” зэрэг зорилтууд тусгагдсан.

Ахмад настны тухай хууль, Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд ахмад настанд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чиг хандлагыг дээшлүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурал 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “цалингийн” гэсний өмнө **“төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган”** гэж нэмж, *“Энэ хуулийн 14.6⁸-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.”* гэж өөрчлөн найруулсан байна.

Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж байна.

Ахмадын сан байгуулан ажиллуулах журамд дараах зохицуулалтыг шинээр тусган оруулсан байна. Тухайлбал:

⁵ Хоёр. Хүний хөгжил. Хөдөлмөрийн зах зээл.Зорилт: Хүн амын бүлгүүд, тухайлбал эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.

⁶ Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга. Зорилт: Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.

⁷ Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга. Зорилт: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.

⁸14.6 дахь хэсэг. Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.

- Төсвийн байгууллага нь санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын “Ахмадын сан” гэсэн зориулалтад тусган батлуулж, тухайн байгууллагын ахмадын санд шилжүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх;
- төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын санд шилжүүлэх хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 42.3⁹-т заасны дагуу шийдвэрлүүлнэ.
- Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тусгаж, Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг зөрчсөн тохиолдолд Ахмад настны тухай хуулийн 16¹⁰ дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

“ Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 2.1-т Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллага, төсөвт байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;
- сангийн үйл ажиллагаанаас олох орлого;
- сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;
- гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;
- сангийн хөрөнгийн үлдэгдлийг банканд хадгалуулсны хүүгийн орлого;
- бусад эх үүсвэр.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 221 дүгээр тогтоолын 5¹¹ дахь заалтаар “Ахмадын сан” байгуулан ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосон байдаг.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилтийн хүрээнд төсөвт байгууллагууд “Ахмадын сан” байгуулж, Сангийн яамны санхүүгийн удирдлагын мэдээллийн системд бүртгэлтэй 1049 дансанд 2024 онд 16.787,3 сая төгрөг, 1093 дансанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 13.787,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсөвт байгууллагууд ахмадын сан байгуулан, данс нээгээгүй ч тухайн жилийн төсвийн хэмнэлтээс эх үүсвэрийг бүрдүүлж, цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, түлээ, нүүрс олгох, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээнд зохион байгуулахаар зарцуулж байна.

⁹ Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

42.3.1.төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

42.3.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь саналаа харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

¹⁰ 16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

16.2.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

¹¹ Орон байргүй ахмад настныг түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх, Ахмад настны тухай хуулийн 12.7 дахь хэсгийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, “Ахмадын сан” байгуулан ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

БҮЛЭГ 1. АХМАДЫН САН БАЙГУУЛАХ, ДАНС НЭЭХ, ТҮҮНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Ахмад настны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр төсвийн байгууллагууд “Ахмадын сан” байгуулан ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

1.1 Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан бөгөөд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны хуулиар төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж буй төсөвт байгууллагууд уг хуулийн зорилтыг хангаж, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэрт гарсан албан хаагчдад нэмэгдэл тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс цалингийн сангийн тодорхой хувиар төсөвт тусган сан бүрдүүлэхээр заасан байна.

1.2 Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэгт зааснаар аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд "Ахмадын сан" байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батлахаар зохицуулсан.

1.3 Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг Засгийн газрын 2024 оны 243 тогтоолын 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталж, ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжаас бусад чиглэлээр үзүүлэх дэмжлэгт шаардагдах хөрөнгийг тухайн байгууллагын төсөвт тусган, "Ахмадын сан" байгуулан ажиллуулахаар зохицуулсан байна.

1.4 Дээрх хууль, журмын дагуу төрөөс ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжаас бусад чиглэлээр үзүүлэх дэмжлэгт шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвт тусган, "Ахмадын сан"¹² байгуулан ажиллуулах хууль, эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.

1.5 Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаал баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн данс нээлгэснээр ахмадын сангийн хөрөнгө Төрийн дансанд байрших нарийвчилсан зохицуулалт хууль тогтоомжид тусгагдсанаар ахмадын сангийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналын ил тод байдал хангагдаж, түүнд тавих хяналт сайжрахаар байна.

¹² Журмын 3.10.Төсвийн байгууллага нь ахмадын санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын "Ахмадын сан" гэсэн зориулалтад тусган батлуулж, тухайн байгууллагын ахмадын санд шилжүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлнэ. 3.11.Төсвийн байгууллагын ахмадын санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 42.3-т заасны дагуу төсөвтөө зохицуулалт хийх санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

1.6 Ахмад настны тухай хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Төсөвт байгууллагууд “Ахмадын сан” байгуулан ажиллуулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

1.7 Төрийн захиргааны төв байгууллага эрхэлсэн асуудлын хүрээнд ахмад настанд ая тухтай амьдрах, хөгжих, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломж олгох талаар бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

1.8 Төрийн аудитын байгууллагын “Санхүүгийн тайлангийн аудитын систем”-д бүртгэлтэй 4721 төсөвт байгууллагуудаас 3628 буюу 76.9 хувь нь ахмадын сан байгуулж данс нээгээгүй нь Ахмад настны тухай хуулийн 14.7¹³ дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүйг харуулж байна. /Хавсралт 1-д харуулав./

1.9 Сангийн яамны санхүүгийн удирдлагын мэдээллийн системд нийт 1093 Ахмадын сангийн данс бүртгэлтэй байгаагаас 1012 буюу 92.5 хувь нь 2017-2023 онд, 81 буюу 7.5 хувь нь 2024-2025 онд нээсэн бөгөөд түүний 450 буюу 40 гаруй хувь нь идэвхгүй төлөвтэй, хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

1.10 Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 2.1-д сангийн хөрөнгийг төсөвт байгууллагын тухайн жилийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө, сангийн үйл ажиллагаанаас олох орлого, гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан боловч ахмадын сангийн хөрөнгийг цалингийн хэмнэлтийн тодорхой хувь болон төсвийн бусад зардлын хэмнэлтээс зохицуулан зарцуулж байна.

1.11 Төрийн аудитын байгууллагаас ахмадын сангийн хөрөнгө бүрдүүлэлтийн байдалд түүвэрлэн судалгаа хийхэд нийт бүрдүүлсэн орлогын 90-ээс дээш хувийг цалингийн сангийн тодорхой хувь хэмжээгээр төвлөрүүлсэн хөрөнгө байх бөгөөд журамд заасан бусад эх үүсвэрээс бүрдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.12 Санхүүгийн тайлангийн аудитын явцад Ахмадын сангийн данс нээж, төсөвт батлуулан зарцуулах талаарх хуулийн тогтоомжийн заалтын хэрэгжилтэд түүвэрчлэн хянахад зарим төрийн байгууллага ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт төлөвлөж, батлуулахгүйгээр тайлант оны төсвийн хэмнэлтээс зарцуулсан байна.

¹³ Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.

Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүн

1.13 Санхүүгийн тайлангийн аудитаар Ахмад настны тухай хуулийн 14.7-д төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан Ахмадын сан байгуулан ажиллах журмын 1.3-т төсөвт байгууллагын тухайд сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана гэсэн заалтуудыг биелүүлж ажиллаагүй зарим төсөв захирагч нарт зөвлөмж хүргүүлсэн.

1.14 Төрийн санд бүртгэлтэй төрийн байгууллагуудын ахмадын сангийн дансны нийт үлдэгдэл 2024 оны жилийн эцэст 16,787.3 сая төгрөг, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 13,257.0 сая төгрөг байна.

Хүснэгт 1. Ахмадын сангийн хөрөнгийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Д/д	Төсөвт байгууллага	2024		2025	
		Дансны тоо	Дансны үлдэгдэл	Дансны тоо	Дансны үлдэгдэл
1	Авлигатай тэмцэх газар	1	368.3	1	304.3
2	Батлан хамгаалах яам			44	380.5
3	Боловсролын яам	227	1,503.4	227	1,207.3
4	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	70	734.1	70	520.8
5	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	3	660.6	3	623.8
6	Ерөнхий Прокурорын газар	2	934.0	2	825.1
7	Хүний эрхийн Үндэсний Комисс	1	72.5	1	57.0
8	Шадар сайдын ажлын алба	33	362.4	33	210.4
9	Шүүхийн ерөнхий зөвлөл	43	192.3	43	125.2
10	Санхүүгийн зохицуулах хороо	1	147.7	1	122.9
11	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	79	500.2	79	404.0
12	Сангийн яам	29	1,169.5	29	983.4
13	Улсын Их Хурлын Тамгын газар	1	426.9	1	392.0
14	Үндэсний аудитын газар	4	171.5	4	98.1
15	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	1	7.4	1	26.2
16	Үндэсний статистикийн хороо	7	21.5	7	11.9
17	Хууль зүй, дотоод хэргийн яам	156	5,294.2	156	3,553.7
18	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	22	153.9	22	119.2
19	Эрүүл мэндийн яам	92	306.9	92	263.6
20	Бусад	277	3,760.2	277	3,027.5
	Нийт	1049	16,787.3	1093	13,257.0

Эх сурвалж: / Сангийн яамны санхүүгийн удирдлагын мэдээллийн систем/

1.15 Судалгаанаас харахад 2025 онд төсөвт байгууллагуудын дансны тоо 44-өөр нэмэгдсэн байгаа нь Ахмад настны тухай хууль хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын хэрэгжилт хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИХ, НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.1 Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүрэг хүлээнэ.” гэж заасан.

2.2 Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.” гэж тус тус заасан.

2.3 Ахмадын сан байгуулан ажиллах журмын 3.1¹⁴-д Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6 дахь хэсэгт заасны дагуу байгууллагын төсөв болон дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүргийг төсвийн захирагчид хариуцахаар тусгасан.

2.4 Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар 2025 оны 01/634 дугаар албан бичгээр “Ахмадын сан” байгуулах тухай бүх сайд нарт, 01/1942 дугаар албан бичгээр Хууль тогтоомж гэрээний хэрэгжилт, судалгаа ирүүлэх тухай Аймаг, Нийслэлийн засаг дарга нарт чиглэлийг хүргүүлж ажилласан байна.

2.5 Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч болон Аймаг, Нийслэлийн засаг дарга нарт дээр ахмадын сан байгуулан, данс нээж ажиллах чиглэлийг хүргүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнахаар ажиллаж байна.

2.6 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ахмад настны тухай хууль болон Засгийн газрын баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын

¹⁴ Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан арга хэмжээнд зарцуулна.

хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүргийг хуулиар хүлээсэн боловч чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Ахмадын сангийн хөрөнгийг хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.7 Ахмадын сан байгуулан ажиллуулах журамд зааснаар сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналт, санхүүгийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу, аймаг, нийслэл, сум, дүүргийн ахмадын байгууллага “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавихаар тусгагдсан байна.

2.8 Төсвийн захирагчдын Ахмадын сан байгуулсан хөрөнгийн зарцуулалтыг 2024 оноор түүвэрлэн хянахад дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Д/д	Хөрөнгө зарцуулалтын төрөл	Хүснэгт 2 /сая.төгрөг/	
		Данс	Зарцуулалтын дүн
1	Байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох	52	313.1
2	Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах	464	3,227.5
3	Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх	84	279.8
4	Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	13	25.1
5	Шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх	5	23.8
6	Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх	109	238.9
7	Ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох	83	171.1
8	Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	106	510.8
9	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангүй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж үзүүлэх	11	30.9
10	Хуульд заасан хүрээнд ахмад настанд чиглэсэн бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх	59	531.5
	Нийт		5,352.5

Эх сурвалж: /Аудитын судалгааны нэгтгэл/

2.9 Төсөвт байгууллагууд ахмадын санд бүрдүүлсэн хөрөнгийн 60 гаруй хувийг журмын 3.1.2¹⁵-т заасны дагуу Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах зориулалтаар зарцуулжээ.

2.10 Ахмадын сангийн хөрөнгийг хууль, журамд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглосон боловч зориулалтын дагуу зарцуулаагүй дараах алдаа зөрчлүүд аудитаар илэрсэн. Тухайлбал:

- *Ахмадын сангийн батлагдсан төсвийг "Ахмадын сан"-д төвлөрүүлээгүй, батлагдсан төсвийг илүү зарцуулсан;*
- *Төсвөөс төвлөрүүлсэн ахмадын сангийн хөрөнгийг арилжааны банкны харилцах дансанд байршуулж, зарцуулсан;*
- *Ахмадын сангийн хөрөнгөөр албан хаагчдын урамшуулал олгосон;*
- *Баярыг ёслолын арга хэмжээг тохиолдуулан ахмадын сангийн зардлаас гарын бэлэг олгосон;*
- *Ахмадын сангийн хөрөнгөөр байгууллагын албан хаагчдын аяллын зардлыг шийдвэрлэсэн;*
- *Ойн арга хэмжээнд ахмадын сангаас хөрөнгө зарцуулсан гэх мэт.*

2.11 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Ахмад настны тухай хууль, журамд заасан арга хэмжээнд сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр 66.7 сая төгрөгийн зөрчилд нийт 9 албан шаардлага, ахмадын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 9.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэх 3 төлбөрийн акт тогтоосон.

2.12 “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 4.3-т “Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж, байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлд тайлагнана”, 4.4.-т “Аймаг, нийслэл, дүүргийн ахмадын байгууллага энэхүү журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавина.” гэсэн холбогдох заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

¹⁵ Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн, бэлэг дурсгалын зүйл гардуулах;

ДҮГНЭЛТ

Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох баримтыг үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэгт орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2024 оны 243 тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам”-ын 3.10, 3.11-д орсон нэмэлт, өөрчлөлтүүд төсвийн байгууллагуудад “Ахмадын сан” байгуулан ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон байна.
2. Төсвийн байгууллага хуульд зааснаар “Ахмадын сан”-г тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр байгуулаагүй нь Төрийн байгууллагууд шат шатандаа үр дүнтэй арга хэмжээ авч, хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.
3. Төрийн аудитын байгууллагын “Санхүүгийн тайлангийн аудитын систем”-д бүртгэлтэй 4721 төсөвт байгууллагуудаас 3628 буюу 76.9 хувь нь ахмадын сан байгуулж данс нээгээгүй, төсвийн байгууллагууд Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.
4. Сангийн яамны санхүүгийн удирдлагын мэдээллийн системд нийт 1093 байгууллагын данс бүртгэлтэй байгаагаас 1012 буюу 92.5 хувь нь 2017-2023 онд, 81 буюу 7.5 хувь нь 2024-2025 онд нээснээс 450 буюу 40 гаруй хувь нь идэвхгүй төлөвтэй буюу хөрөнгө төвлөрүүлээгүй байна.
5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ахмад настны тухай хуулиар төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах гэсэн хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМАНД:

1. Ахмад настны тухай хууль тогтоомж болон холбогдох Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах талаар үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудыг Ахмадын сан байгуулж, Төрийн санд данс нээн, хөрөнгө бүрдүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах.

САНГИЙН ЯАМАНД:

3. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилийн төсвийг боловсруулахдаа төсөв захирагчдын саналыг үндэслэн Ахмадын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн бодлоготой уялдуулан төлөвлөж шийдвэрлүүлэх.

АХМАДЫН САНГИЙН ДАНСНЫ СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

Д/д	Аймаг	Төсөвт байгууллага	Ахмадын сангийн данс	Идэвхтэй	Идэвхгүй
1	Улаанбаатар	1146	206	140	68
2	Архангай	181	13	6	7
3	Баян-Өлгий	199	32	11	21
4	Баянхонгор	189	20	13	7
5	Булган	154	33	8	23
6	Говь-Алтай	184	11	9	2
7	Говьсүмбэр	57	53	45	8
8	Дархан-Уул	114	33	17	16
9	Дорноговь	170	112	95	17
10	Дорнод	156	18	12	6
11	Дундговь	141	145	132	13
12	Завхан	211	31	18	13
13	Орхон	105	68	18	50
14	Өвөрхангай	206	22	8	14
15	Өмнөговь	163	32	20	12
16	Сүхбаатар	138	13	9	4
17	Сэлэнгэ	220	13	10	3
18	Төв	222	19	7	12
19	Увс	181	8	2	6
20	Ховд	177	12	5	7
21	Хөвсгөл	216	99	15	84
22	Хэнтий	191	100	43	57
	Нийт	4721	1093	643	450

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.11.04 № 02/3575
танай -ны № -т

Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БАТТУЯА ТАНАА

Танаас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Тайлангийн төсөлд санал авах тухай" 08/3102 дүгээр албан бичгээр ирүүлсэн Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Улсын Их Хурлаас 2017 онд Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуульд ахмад настны эрх, хөгжил оролцоо, амьжиргаа, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн дэмжлэг болон хүндэтгэлийн арга хэмжээг тусган, төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга, ахмадын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой заасан юм.

Иймээс Ахмад настны тухай хууль нь олон салбарын оролцоотойгоор хэрэгжих, салбар дундын зохицуулалттай томоохон хууль юм.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу манай яам ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад настны хөгжил, оролцоог дэмжих, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүрэг хүлээсэн.

Энэ хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024-2025 онд Засгийн газрын тогтоолоор холбогдох журмууд болон Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдтай хамтран ахмад настны цогц үнэлгээ, түүнд суурилсан цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам, ахмадын үйлчилгээний үнэ тариф, иргэний хариуцан төлөх төлбөрийн хэмжээг тогтоох тушаалуудыг батлуулан мөрдөж байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр "Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна. Тус яамнаас 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хуулийн нэмэлт, өөрчлөлт хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой эхний хагас жилд аймаг, дүүргийн Засаг дарга нарт хууль, журмыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах албан бичиг, харьяа агентлаг, байгууллагад анхан шатны нэгж, нийгмийн ажилтан, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиглэлийг тус тус өгч

D: 2025 on 11 sar A4

Тайлбар 1

ажиллаж байна. Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн ахмадын байгууллага, ахмад настануудад Ахмад настны тухай хууль тогтоомжийн талаар сургалт, танилцуулга, хэлэлцүүлэг олон удаа хийсэн ба 2024 оны 11 дүгээр сард Монголын Ахмадын холбоотой хамтран бүсийн сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Танай байгууллагаас хийсэн Ахмадын сангийн хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналтай байна. Үүнд:

1. Аудитын дүгнэлтийн 2 дахь заалтад Төрийн байгууллагууд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс ахмад настанд үзүүлэх арга хэмжээнд зарцуулсан нь Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэг болон "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь заалттай нийцэхгүй байна гэжээ.

Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан "Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага **тухайн жилийн төсөвт тусган** цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэсэн өөрчлөлт оруулсан.

Төсвийн байгууллагуудын хувьд ахмадын сангийн хөрөнгө төсөвт батлагдаагүй, төсөвт тусгуулах санал хүргүүлсэн боловч төсөв хянагдах явцад хасагдсан гэх шалтгаанаар хэрэгжилт хангалтгүй байсныг сайжруулах зорилгоор төсөвт байгууллагууд заавал тухайн жилийн төсөвтөө ахмадын сангийн хөрөнгийн төсвийг тусгах үүрэгжүүлсэн заалтыг хуульд оруулан батлуулсан юм.

Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын хавсралтаар "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-д дараах зохицуулалтыг тодорхой тусгасан. Үүнд:

- аж ахуйн нэгж, байгууллага, төсвийн байгууллага нь ахмад настны тооноос хамааран санг цалингийн сангийн хэдэн хувиар тогтоох асуудлыг хоёр жилд нэг удаа байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлтэй хэлэлцэн тогтоож, нийт ажилтны хуралд танилцуулах;

- төсвийн байгууллага нь санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын "Ахмадын сан" гэсэн зориулалтад тусган батлуулж, санхүүжүүлэх;

- төсвийн байгууллага нь санд шилжүүлэх хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн шууд захирагч төсөвт зохицуулах хүсэлтээ Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид гаргаж, байгууллагын ахмадын сан зориулалтын холбогдох эдийн засгийн ангилалд шилжүүлэх;

- сангийн хөрөнгийн зарцуулалтыг тусгаж, Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан.

Ингэснээр аж ахуйн нэгж, байгууллага, төсвийн байгууллага нь тухайн жилийн төсөвтөө Ахмадын сангийн хөрөнгийг тусган батлуулж, санг ямар нэг хоёрдмол утга, үл ойлголцолгүйгээр байгуулан ажиллуулах боломж бүрдүүлсэн.

Хуулийн нэмэлт, өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Тайлбар 2

2.Аудитын дүгнэлтийн 3 дахь заалтад "Төсөвт байгууллагын 76.9 хувь нь Ахмадын сан байгуулж, данс нээгээгүй нь Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна" гэжээ.

"Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.12-т Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ" гэж заасан.

Төсвийн тухай хуулиар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь банканд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих төсвийн удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Төсвийн байгууллагуудын төсвийн саналд тусган хүргүүлсэн Ахмадын сангийн төсвийг хянах, дансыг нээх асуудал Сангийн яамны үндсэн чиг үүрэгт хамаардаг тул хууль журмын хэрэгжилтийг хангахад тус яаманд зөвлөмж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын хэрэгжих хугацаа нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн. Төсвийн тухай хууль, төсвийн цаглабарын дагуу 2025 оны төсвийн санал, төсвийн хязгаар, төсөв батлагдах явцад буюу 2024 онд дээрх хууль, журам мөрдөгдөж эхлээгүй байсантай холбоотой Дүгнэлт 2, 3-д Ахмадын сангийн хэрэгжилт хангалтгүй, зориулалтын бус ангиллаас сангийн үйл ажиллагаанд зарцуулсан гэсэн дүгнэлт гарчээ.

Тайлбар 3

3.Аудитын дүгнэлтийн 6 дахь заалтад "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна" гэжээ.

Ахмад настны тухай хуулийн 14.1, 14.2, 14.3, 14.4-т Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Эрүүл мэндийн, Боловсролын яам болон бусад яамдын эрхлэх асуудлын хүрээнд хариуцах чиг үүргийг тодорхой тусгасан байх ба 14.5-д бүх шатны Засаг дарга нарын, 14.6-д бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүргийг тусгасан байдаг.

"Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 4.1-д "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, төсвийн байгууллагын шууд захирагч хариуцан гүйцэтгэнэ" гэж, мөн журмын 4.5-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ахмадын байгууллага энэ журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавина" гэж тус тус заасан.

Салбарын хууль тогтоомжийн хүрээнд манай яамнаас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/634 дүгээр албан бичгээр бүх төрийн захиргааны төв байгууллагад Ахмадын санг байгуулан хэрэгжилтийг сайжруулах талаар, мөн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/1992 дүгээр албан бичгээр бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нарт харьяа төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн Ахмадын сангийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээлэл ирүүлэх чиглэл хүргүүлж ажилласан.

Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээнд Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг тусгасан:

D: 2025 on 11 sar A4

- ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ;
- асаргааны хувилбарт үйлчилгээ;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;
- Ахмадын сан байгуулан ажиллуулах;
- тэтгэвэрт гарсан ахмад настнууд, багш, эмч нарыг салбарт нь үргэлжлүүлэн ажиллуулах;
- ахмад настны эрхийг хамгаалах, хөгжил оролцоог дэмжих.

Ахмад настны тухай хуулийн 15.1-д "Ахмад настны олонхийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, нийгэмд үйлчилдэг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг улсын төсвөөс, түүний салбар, нэгжийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжүүлнэ", 15.2-т "Энэ хуульд заасан ахмад настны талаархи төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг ахмад настны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно" гэж заасан.

Мөн Засгийн газрын 2016 оны "Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 124 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яам, Монголын ахмадын холбоотой жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Монголын ахмадын холбоотой байгуулсан гэрээнд "Аж ахуйн нэгж, байгууллагад Ахмадын сан байгуулах талаар мэдээлэл өгч ажиллах" гэж тусгагдсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэдэг.

Сангийн сайдын 2015 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" А/07 дугаар тушаалын хавсралтаар баталсан Зардлын эдийн засгийн ангилалд "Ахмадын сан" гэсэн ангилал батлагдаагүйгээс төсвийн байгууллагууд ахмадын санд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган батлуулахад хүндрэл үүсэж байсан. Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.10-д "Төсвийн байгууллага нь ахмадын санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын "Ахмадын сан гэсэн зориулалтад тусган батлуулж, тухайн байгууллагын ахмадын санд шилжүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлнэ" гэсэн зохицуулалт нэмж оруулсан юм.

Түүнчлэн Ахмадын санг төсвийн байгууллагаас гадна улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдуулан Компанийн тухай хуулийн 16.2.8-д "Ахмадын сан" байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох" гэж нэмснээр компанийн дүрэмд заавал тусгах асуудалд "Ахмадын сан"-г оруулсан.

Иймд Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан Ахмадын сангийн хэрэгжилт бүх төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, түүний удирдлага, түүнчлэн бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үүрэг, хариуцлагад хамаарах асуудал тул Дүгнэлтийн 6-д дурдсан Ахмадын сангийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангах үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн нь хэт өрөөсгөл дүгнэлт байна.

Харин Ахмадын сан нь төсөв, санхүүтэй илүү холбоотой асуудал тул төсвийг батлуулах, хэрэгжилтийг сайжруулах чиглэлд Сангийн яамны үүрэг, оролцоо чухал бөгөөд энэ талаар зөвлөмжийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Үндэсний аудитын газрын тайлбар

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Аудитын судалгаа, нотлох баримтаар Төрийн байгууллагууд төсвийн зарцуулаагүй үлдэгдлээс ахмад настанд үзүүлэх арга хэмжээнд зарцуулж байгаа нь нотлогдож байгаа бөгөөд танай ирүүлсэн саналд тус дүгнэлттэй холбоотой тайлбар ирүүлээгүй байна. Ахмад настны тухай хуулиар төсвийн байгууллагууд ахмадын сангийн данс нээж, цалингийн зардлаас зохих хувийг төсөвтөө тусган батлуулж, зарцуулах үүргийг хүлээсэн байдаг.
Тайлбар 2	Сангийн яамны санхүүгийн удирдлагын системээс авсан мэдээлэлд аудитын багийн хийсэн дүн шинжилгээний үр дүнгээр “Санхүүгийн тайлангийн аудитын систем”-д бүртгэлтэй 4721 төсөвт байгууллагуудаас 3628 буюу 76.9 хувь нь “Ахмадын сан” байгуулж данс нээгээгүй нь тодорхойлогдож байгаа тус саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 3	Аудитын тайланд Ахмад насны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй талаар нотлох баримттай дурдсан тул уг саналыг хүлээн авах шаардлагагүй тул өөрчлөлт оруулаагүй болно.

Монгол улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn